

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН
ЦЭРЭНДОРЖИЙН ЛХАГВАСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. " Санхүү, төсвийн чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дүүргийн орон нутгийн төсвийн төслийг боловсруулж батлуулах, тайлагнах."							
1.	Арга хэмжээ 1.1. Орон нутгийн 2025-2027 оны төсвийн хүрээний дунд хугацааны төлөвлөгөөний төслийг төсвийн төлөвлөлтийн шинэ программд нэгтгэн батлуулж, Нийслэлийн төрийн санд хүргүүлж нэгтгүүлэх	Хуулийн хугацаанд нэгтгэгдсэн эсэх	2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгэгдсэн.	.	2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгэгдсэн байна.	7	8
2.	Арга хэмжээ 1.2. Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж, ИТХуралд өргөн барьж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Хуулийн хугацаанд батлуулсан эсэх	2024 оны орон нутгийн төсөв 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан.		2025 оны орон нутгийн төсөв хуулийн хугацаанд батлагдсанаар төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлнэ.	11	12

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
3.	Арга хэмжээ 1.3. Төсвийн тодотгол хийх шаардлага, нөхцөл, хуулинд заасан үндэслэл үүссэн тухай бүр тодотголын саналыг боловсруулан хянуулж, ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулах	Нэмэлт өөрчлөлт хийгдсэн эсэх	2023 онд орон нутгийн төсөвт 5 удаагийн нэмэлт өөрчлөлт хийгдсэн.	Төсвийн нэмэлт өөрчлөлт хийгдсэнээр төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл хангагдана.	Төсвийн нэмэлт өөрчлөлт хийгдсэнээр төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл хангагдана.	1	12

Зорилт 2. "Төсөвт байгууллагуудын төсвийн саналыг хуулийн хугацаанд хүлээн авч, норм, нормативыг үндэслэн үр ашигтай төсөвлөх, төсвийн зарцуулалтад хяналт тавих."

1.	Арга хэмжээ 2.1. Орон нутгийн 2024 оны батлагдсан төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг төсөвт байгууллага, зардал бүрээр боловсруулж батлуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих	Сарын төсвийн хуваарь батлагдсан эсэх, зарцуулах эрх нээлгэсэн байгууллагын тоо	2023 оны дүүргийн орон нутгийн 31 байгууллага, хөтөлбөр, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны А/22 захирамжаар батлуулж, 11-13 байгууллагын нийт 3,012.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийг нээсэн байна.	Орон нутгийн байгууллагуудын хуваарь хугацаандаа батлагдан, санхүүжилт бүрэн олгогдох нөхцөл хангагдсан байна.	Орон нутгийн байгууллагуудын хуваарь хугацаандаа батлагдан, санхүүжилт бүрэн олгогдох нөхцөл хангагдсан байна.	1	12
----	---	---	---	--	--	---	----

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
2.	Арга хэмжээ 2.2. Орон нутгийн байгууллагуудын төсвийн сар улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн Фискал-5.5 програмд байгууллага бүрээр шивж нэгтгэн бааз үүсгэж, Төв төрийн санд илгээж, сар, улирлын хуваарийг татуулах	Төлөвлөлтийн програмд нэгтгэсэн эсэх	2023 оны орон нутгийн төсвийн төлөвлөлт Фискал програмд бүрэн нэгтгэгдэн, төрийн сангийн төлбөр тооцоо зөрчилгүй хийгдсэн.	Төсвийн төлөвлөлт Фискал програмаар хийгдэн төсвийн хуваарь програмд бүрэн нэгтгэгдэж, төлбөр тооцоо хийгдэх нөхцөл бүрдсэн байна.	Төсвийн төлөвлөлт Фискал програмаар хийгдэн төсвийн хуваарь програмд бүрэн нэгтгэгдэж, төлбөр тооцоо хийгдэх нөхцөл бүрдсэн байна.	1	12
3.	Арга хэмжээ 2.3. Дүүргийн удирдлагууд болон холбогдох байгууллагуудад шаардлагатай санхүүжилт, төсвийн төлөвлөлттэй холбогдолтой мэдээ судалгааг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, дүгнэлт хийх, тайлбар, танилцуулга бэлтгэх, бодит хэмнэлтийн тооцоо судалгааг гаргаж мэдээллээр хангаж ажиллах	Мэдээ, тайлан, танилцуулга хугацаандаа нэгтгэгдсэн эсэх	Нийт 17 удаа удирдлагад мэдээ, тайлан, танилцуулга танилцуулж, мэдээллээр ханган ажилласан.	Мэдээ, тайлан, танилцуулгыг хугацаанд нь бүрэн нэгтгэн хүргүүлсэнээр хэлтсийн үйл ажиллагааны биелэлт хангагдана.	Мэдээ, тайлан, танилцуулгыг хугацаанд нь бүрэн нэгтгэн хүргүүлсэнээр хэлтсийн үйл ажиллагааны биелэлт хангагдана.	1	12
Зорилт 3. "Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх."							
1.	Арга хэмжээ 3.1. Засаг даргын захирамжаар зохион байгуулагдах нөөц хөрөнгө, төсөл хөтөлбөрөөс санхүүжих ажил үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн төсвийг хянаж, зарцуулалтанд хяналт тавих, удирдлагыг мэдээллээр хангах	Төсвийг зориулалтын дагуу төлөвлөсөнг хянасан эсэх	Төсвийн зарцуулалт зориулалтын дагуу холбогдох анхан шатны баримтаар баталгаажин зарцуулагдсан байна.	Төсвийн зарцуулалт зориулалтын дагуу холбогдох анхан шатны баримтаар баталгаажин зарцуулагдсан байна.	Төсвийн зарцуулалт зориулалтын дагуу холбогдох анхан шатны баримтаар баталгаажин зарцуулагдсан байна.	1	12

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
2.	Арга хэмжээ 3.2. Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээлвэл зохих мэдээ, тайланг хуулийн хугацаанд тогтмол байршуулах, хянах, тайлагнах	Мэдээний тоо, хуулийн хугацаанд байршуулсан эсэх	Нийт 30 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан.	Хуулинд заасан хугацаанд байршуулсан байна.	Хуулинд заасан хугацаанд байршуулсан байна.	1	12
3.	Арга хэмжээ 3.3 Цаг үеийн шинжтэй дарга удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэн, биелэлтийг тухай бүрт тайлагнах.	Үүрэг даалгаврыг биелүүлсэн эсэх	Удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэн, тайлагнаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэн, тайлагнаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэн, тайлагнаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	1	12
4.	Арга хэмжээ 3.4 Цахим баримт бичгийг цахим албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого, стандарт, журмыг хэрэгжүүлэн, мэдээллийн аюулгүй байдлыг ханган, шуурхай хянан шийдвэрлэх,	Шийдвэрлэсэн хувь	Шийдвэрлэлтийн хувь 99.77%	Цахимаар ирсэн баримт бичгийг 94 хувиас доошгүй хувьд шуурхай хянан, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	Цахимаар ирсэн баримт бичгийг 94 хувиас доошгүй хувьд шуурхай хянан, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	1	12
5.	Арга хэмжээ 3.5 Өргөдөл гомдолыг шуурхай хянан шийдвэрлэх,	Шийдвэрлэсэн дундаж хугацаа	Шийдвэрлэлтийн дундаж 4,5 хоног	Өргөдөл, гомдлыг шуурхай хянан, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	Өргөдөл, гомдлыг шуурхай хянан, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	1	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
6.	Арга хэмжээ 3.6 Баримт бичгийг MNS5140:2011 стандартыг мөрдөн боловсруулах,	MNS5140:2011 стандартыг мөрдсөн эсэх	2023 онд 77 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн MNS5140:2011 стандартын дагуу төлөвлөсөн.	MNS5140:2011 стандартыг мөрдөн боловсруулан ажилласан байна.	MNS5140:2011 стандартыг мөрдөн боловсруулан ажилласан байна.	1	12
7.	Арга хэмжээ 3.7 Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн, баримт бичиг хүлээн авах хуваарийн дагуу байгууллагын архивт шилжүүлэх,	Архивын нэгжийн тоо, тогтоосон хугацаанд хүргүүлсэн эсэх	2022 оны нийт 9 хавтас архивын нэгж үүсгэсэн.	Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн хэрэг бүрдүүлэн цэгцэлсэн байна.	Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн, хуваарьт хугацаанд байгууллагын архивт өгсөн байна.	1	12
8.	Арга хэмжээ 3.8 Яам, нийслэл, дүүрэг, тамгын газар, хэлтсээс зохион байгуулсан олон нийтийн ажлуудад оролцох	Зохион байгуулсан ажилд оролцох хувь	Зохион байгуулсан ажлын 80-аас доошгүй хувьд оролцсон.	Зохион байгуулсан ажлын 85-аас доошгүй хувьд оролцсон байна.	Зохион байгуулсан ажлын 85-аас доошгүй хувьд оролцсон байна.	1	12

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн МНБ-ын тасралтгүй хөгжлийн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан эсэх	4 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлүүлэн онлайн сургалтад суралцаж, 5 дугаар сарын 08-ны өдрөөс 12-ны өдрүүдэд танхимийн	МНБ-ын тасралтгүй боловсролын сургалтын хөтөлбөрийн хичээлийг бүрэн	МНБ-ын тасралтгүй боловсролын сургалтын хөтөлбөрийн хичээлийг бүрэн	1	12

			сургалтад бүрэн хамрагдсан.	суралцсан байна.	суралцсан байна.		
2.	Арга хэмжээ 2. Нийслэл, дүүргээс зохион байгуулсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан эсэх	-	Нийслэл, дүүргээс зохион байгуулсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтын хөтөлбөр болон Төрийн албаны зөвлөлийн төлөвлөгөөт сургалтуудад хамрагдсан байна.	Нийслэл, дүүргээс зохион байгуулсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтын хөтөлбөр болон Төрийн албаны зөвлөлийн төлөвлөгөөт сургалтуудад хамрагдсан байна.	1	12
	Арга хэмжээ 3. Удирдлагын Академийн "Төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн багц сургалт"-д хамрагдах	Суралцсан кредит цаг		Мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийн хичээлийг дүүргэж, төгссөн байна.	Мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийн хичээлийг дүүргэж, төгссөн байна.	1	12

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

Төсвийн мэргэжилтэн

..... Ц.Лхагвасүрэн

2024. 01. 05

(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга



..... М.Догзолмаа

2024. 01. 05

(Огноо)

**САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН ЦЛХАГВАСҮРЭНГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
1	2	3	4	5	6	7	8
Стратегийн зорилго 1. Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ.							
Зорилт 1. "Санхүү, төсвийн чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дүүргийн орон нутгийн төсвийн төслийг боловсруулж батлуулах, тайлагнах."							
1	Арга хэмжээ 1.1. Орон нутгийн 2025-2027 оны төсвийн хүрээний дунд хугацааны төлөвлөгөөний төслийг төсвийн төлөвлөлтийн шинэ программд нэгтгэн батлуулж, Нийслэлийн Санхүү, төрийн санд хүргүүлж нэгтгүүлэх	Хуулийн хугацаанд нэгтгэж, илгээсэн эсэх	2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгэгдсэн.	2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгэгдсэн байна.	Дүүргийн орон нутгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн 2025-2027 оны төлөвлөгөөний төслийг орон нутгийн 10 байгууллага, 23 сургууль, 40 цэцэрлэг, АБНТТөв, Биеийн тамир спортын хороо, Соёлын ордон зэрэг боловсрол, биеийн тамир, спортын байгууллагуудаас хүлээн авч, нэгтгэн 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.	2024.07.01-2024.08.31	100%
	Арга хэмжээ 1.2. Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж, ИТХуралд өргөн барьж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Дүүргийн төсөв баталсан ИТХ-ын тогтоол	2024 оны орон нутгийн төсөв 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан.	2025 оны орон нутгийн төсвийн төслийг хуулийн хугацаанд ДИТХ-д өргөн барьж батлуулна.	Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төлөвлөгөөний төслийг орон нутгийн 10 байгууллага, 23 сургууль, 40 цэцэрлэг, АБНТТөв, Биеийн тамир спортын хороо, Соёлын ордон зэрэг боловсрол, биеийн тамир, спортын байгууллагуудаас хүлээн авч нэгтгэх, дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт,	2024.11.01-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					ногоон байгууламж, гэрэлтүүлэг, камерыг нэмэгдүүлэх, засварлах, явган болон дугуйн авто зам барих, гэр хорооллын автозамыг өргөтгөн шинэчлэх, засварлах, айл өрхийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, засварлах, 2024-2028 онд Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт зориулагдах зардлыг нэгтгэх ажлуудыг гүйцэтгэж, иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж батлуулах бэлтгэл ажил хангагдсан байна.		
	Арга хэмжээ 1.3. Төсвийн тодотгол хийх шаардлага, нөхцөл, хуулинд заасан үндэслэл үүссэн тухай бүр тодотголын саналыг боловсруулан хянуулж, ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулах	Тухай бүр хийгдсэн төсвийн тодотголын төсөл, батлагдсан өөрчлөлт	2023 онд орон нутгийн төсөвт 5 удаагийн нэмэлт өөрчлөлт хийгдсэн.	Төсвийн нэмэлт өөрчлөлтийг тухай бүр тусгаж, тодотгон ДИТХ-аар батлуулна.	2024 оны 02 дугаар сарын 29, 2024 оны 04 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 04-ний өдрийн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар 2024 оны орон нутгийн төсөвт нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт оруулан, батлуулав. Үүнд: 1. Нийслэлд төвлөрүүлэх шилжүүлгийн орлого 2024 оны Нийслэлийн төсвийн тодотголоор хасагдан 335,046,756.5 мянган төгрөг, 2. Орон нутгийн төсвийн орлогыг жигд ханган биелүүлэх, татвар төлөгчдийн бааз суурь, татвар төлөлтийг нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад татварын хууль	2024.01.02-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					тогтоомжийг сурталчлан таниулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хэлтсийн төрийн албан хаагчдыг урамшуулах, нийгмийн баталгаа хангах арга хэмжээний зардалд Татварын хэлтэст нийт 200.0 сая төгрөг төсөвлөн, 3. Хан-Уул дүүргийн 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан 115 төсөл арга, хэмжээнээс 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Засаг даргын зөвлөлийн ээлжит хурлаар 3 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг бууруулах, 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг бууруулж, 2024 онд санхүүжих дүнг нэмэгдүүлэх, 1 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг нэмэгдүүлэх, 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэн хасахаар, 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр өөрчлөн, 2023-2024 он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан 56 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг бууруулан, 4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх дүн		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					153,8 сая төгрөгөөр нэмэгдэж ирж байгаа тул 2024 онд хэрэгжих 4 төсөл, арга хэмжээний 3,270,844.5 мянган төгрөгийг нэмэгдүүлэн 3,424,655.9 мянган төгрөг болгон, нийт 5,990,741.9 төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр, 5. Нийслэлд төвлөрүүлэх шилжүүлэг буурч байгаа тул дүүргийн төсвийн орлогын тасарч буй татварын орлогын нэг төрөл болох Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөөг 4,357.3 сая төгрөгөөр бууруулан нийт төсвийн орлогыг 480,296.5 сая төгрөг болгон бууруулан батлуулах, 6. Цалин, НДШ-ийн зардал, дүүргийн төсвөөс санхүүжиж буй төсвийн байгууллагын албан хаагчдын унаа, хоолны хөнгөлөлт 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 35,000 төгрөг олгохоор тооцоолон хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн Туул тосгоны ажлын алба, Худалдан авах ажиллагааны алба, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Нийтлэг үйлчилгээний албаны урсгал зардлыг нийт 229,1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, хүүхдийн		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					сургуулийн автобусны үйлчилгээний 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны 234,1 сая төгрөгийн урсгал зардлыг дүүргийн 2024 оны төсвийн суурь зарлагаас хасч, 7. Нийтийн эзэмшлийн зам, талбайн цэвэрлэгээ, арчлалтын зардал, хог тээврийн зардал, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд халтиргаа гулгааг арилгахад шаардлагатай давс, бодис худалдан авах зардалд нийт 1 483,0 сая төгрөгний нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлэн хэрэгжүүлэхээр өөрчлөн тус тус тооцооллуудыг тусгасан.		
Зорилт 2. "Төсөвт байгууллагуудын төсвийн саналыг хуулийн хугацаанд хүлээн авч, норм, нормативыг үндэслэн үр ашигтай төсөвлөх, төсвийн зарцуулалтад хяналт тавих."							
2	Арга хэмжээ 2.1. Орон нутгийн 2024 оны батлагдсан төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг төсөвт байгууллага, зардал бүрээр боловсруулж батлуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих	Сарын төсвийн хуваарь батлагдсан эсэх, зарцуулах эрх нээлгэсэн байгууллагын тоо	2023 оны дүүргийн орон нутгийн 31 байгууллага, хөтөлбөр, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг 2023 оны 01	Орон нутгийн байгууллагуудын хуваарь хугацаандаа батлагдан, санхүүжилт бүрэн олгогдох нөхцөл хангагдсан байна.	2024 оны дүүргийн орон нутгийн 31 байгууллага, хөтөлбөр, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан төсвийн дагуу боловсруулж хэлтсийн даргаар хянуулан, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, тухайн байгууллагад хүргүүлж, хяналт тавьж ажиллаж байна. Тайлант	2024.01.02-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
			дүгээр сарын 12-ны А/22 захирамжаар батлуулж, 11-13 байгууллагын нийт 3,012.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийг нээсэн байна.		хугацаанд ИТХ, ЗДТГ, Татварын хэлтэс, Цагдаагийн газар, ГБХЗХХ, ХХҮХ, ОБЕГ-ын ДССЗТөв зэрэг 10 байгууллагын 19 тэрбум 23.7 сая төгрөгийн төсвийн нэмэлт санхүүжилтийн зарцуулах эрхийг нээн, зардлын дансдуудад хуваарилан, төлбөр тооцоо хийх нөхцлийг хангасан.		
	Арга хэмжээ 2.2. Орон нутгийн байгууллагуудын төсвийн сар улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн Фискал-5.5 програмд байгууллага бүрээр шивж нэгтгэн бааз үүсгэж, Төв төрийн санд илгээж, сар, улирлын хуваарийг татуулах	Төлөвлөлтийн програмд нэгтгэсэн эсэх	2023 оны орон нутгийн төсвийн төлөвлөлт Фискал програмд бүрэн нэгтгэгдэн, төрийн сангийн төлбөр тооцоо зөрчилгүй хийгдсэн.	Төсвийн төлөвлөлт Фискал системээр хийгдэн төсвийн хуваарь програмд бүрэн нэгтгэгдэж, төлбөр тооцоо хийгдэх нөхцөл бүрдсэн байна.	Төсвийн орлого, зарлагын жилийн болон сар, улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн Фискал програмд байгууллага бүрээр оруулан нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст илгээн байгууллагуудын төсвийн зарцуулах эрхийг нээлгэж, зарлагын гүйлгээ хийх нөхцлийг хангасан. Батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг зардлын зүйл бүрээр батлуулан сар бүр хяналт тавьж, шаардлагатай орон нутгийн 18 байгууллагын (давтагдсан тоо) төсвийн зохицуулалтуудыг ирүүлсэн саналын дагуу хийж, 5 удаагын захирамж гаргуулан ажилласан байна.	2024.01.02-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
	Арга хэмжээ 2.3. Дүүргийн удирдлагууд болон холбогдох байгууллагуудад шаардлагатай санхүүжилт, төсвийн төлөвлөлттэй холбогдолтой мэдээ судалгааг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, дүгнэлт хийх, тайлбар, танилцуулга бэлтгэх, бодит хэмнэлтийн тооцоо судалгааг гаргаж мэдээллээр хангаж ажиллах	Мэдээ, тайлан, танилцуулга хугацаандаа нэгтгэгдсэн эсэх	Нийт 17 удаа удирдлагад мэдээ, тайлан, танилцуулга танилцуулж, мэдээллээр ханган ажилласан.	Мэдээ, тайлан, танилцуулгыг хугацаанд нь бүрэн нэгтгэн хүргүүлсэнээр хэлтсийн үйл ажиллагааны биелэлт хангагдана.	Орон нутгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл батлуулах болон 2024 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, 2024 оны төсвийн өөрчлөлтийн 4 удаагийн саналыг файл болон илтгэл хэлбэрээр боловсруулан, тухай бүр удирдлагад танилцуулж ажилласан. Тайлант хугацаанд ИТХ, ЗДТГ, Татварын хэлтэс, Цагдаагийн газар, ГБХЗХХ, ХХҮХ, ОБЕГ-ын ДССЗТөв зэрэг 10 байгууллагын 19 тэрбум 23.7 сая төгрөгийн төсвийн нэмэлт санхүүжилтийн зарцуулах эрхийг нээн, зардлын дансдуудад хуваарилан, төлбөр тооцоо хийх нөхцлийг хангасан.	2024.01.02-2024.12.31	100%
Стратегийн зорилго 4. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, дэвшилтэт технологид суурилан түргэн шуурхай хүргэнэ.							
Зорилт 3. "Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх."							
3	Арга хэмжээ 3.1. Засаг даргын захирамжаар зохион байгуулагдах нөөц хөрөнгө, төсөл хөтөлбөрөөс санхүүжих ажил үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн төсвийг хянаж, зарцуулалтанд хяналт тавих, удирдлагыг мэдээллээр хангах	Төсвийг зориулалтын дагуу төлөвлөсөнг хянасан эсэх	Төсвийн зарцуулалт зориулалтын дагуу холбогдох анхан шатны баримтаар баталгаажин зарцуулагдсан байна.	Төсвийн зарцуулалт зориулалтын дагуу холбогдох анхан шатны баримтаар баталгаажин зарцуулагдсан байна.	Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэстэй холбоотой Засаг даргын захирамжийн төслүүд болон байгалийн бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Статистикийн хэлтэс, Газар зохион байгуулалтын албатай холбоотой	2024.01.02-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					гарсан 385 захирамжийн төслийн зардлын тооцоог хянаж ажилласан.		
	Арга хэмжээ 3.2. Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээлвэл зохих мэдээ, тайланг хуулийн хугацаанд тогтмол байршуулах, хянах, тайлагнах	Мэдээний тоо, хуулийн хугацаанд байршуулсан эсэх	Нийт 30 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан.	Хуулинд заасан хугацаанд байршуулсан байна.	Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээлвэл зохих 27 мэдээ, тайланг хуулийн хугацаанд тогтмол байршуулсан.	2024.01.02-2024.12.31	100%
	Арга хэмжээ 3.3 Цаг үеийн шинжтэй дарга удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэн, биелэлтийг тухай бүрт тайлагнах.	Үүрэг даалгаврыг биелүүлсэн эсэх	Удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэн, тайлагнаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэн, тайлагнаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Дүүргийн цэцэрлэг, сургуулийн байгууллагуудын эрхлэгч, захирал нарын 2023 оны үр дүнгийн гэрээг дүгнэх ажлын хэсэгт удирдлагыг төлөөлөн 1 өдөр ажилласан. Нийслэл дэх Төрийн аудитын газарт дүүргийн 2023 оны нэгдсэн санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэн хүргүүлээ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн 2023 оны тайланг Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст мөн Нийслэл дэх Төрийн аудитын газарт файлаар хүргүүлсэн. Нийслэл дэх Төрийн аудитын газраас ирүүлсэн 37, Нийслэлийн	2024.01.02-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					СТСХ-т 4 нэр төрлийн судалгааг нэгтгэн хүргүүллээ. Дүүргийн Улсын дайчилгааны 2024 оны төлөвлөгөөг гаргахад шаардлагатай хүн ам, боловсрол, дэд бүтэц болон эрүүл мэндийн салбарын судалгаа аван нэгтгэл хийн, Нийслэлийн Улсын дайчилгааны мэргэжилтэн болон Батлан хамгаалах яамны Улсын дайчилгааны мэргэжилтэнд файлаар биечлэн хүргүүлэн нэгтгэл тайланд бүрэн нэгтгүүлсэн. АТӨЯХАТ болон агаар бохирдуулсаны төлбөр, автозам ашигласны төлбөр хураах тухай ажлын хэсгийн хуралдаан, мөн дүүргийн камерын нэгдсэн төв ашиглалтад авах тухай ажлын хэсгийн хурал, Хог хаягдал тээвэрлэх зардлын тариф өөрчлөх тухай ажлын хэсгийн хуралд тус тус удирдлагыг төлөөлөн оролцсон. Дүүргийн цэцэрлэг, сургуулийн байгууллагуудын эрхлэгч, захирал нарын 2024 оны хагас жилийн үр дүнгийн гэрээг дүгнэх ажлын хэсэгт удирдлагыг төлөөлөн ажилласан. ОБЕгазраас зохион байгуулсан “Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх” тухай хэлэлцүүлэг, Нийслэлийн Цэргийн штабаас		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					зохион байгуулсан Улсын дайчилгааны мэргэжилтэнүүдийг мэргэжил арга зүйгээр хангах тухай хэлэлцүүлэг, сургалтад тус тус оролцсон. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ХҮН намын бүлгийн хуралд 2024 оны төсвийн нэмэлт өөрчлөлтийн тухай, Ардчилсан намын бүлгийн хуралд 2024 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тухай файл болон илтгэл хэлбэрээр боловсруулан, танилцуулсан.		
	Арга хэмжээ 3.4 Цахим баримт бичгийг цахим албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого, стандарт, журмыг хэрэгжүүлэн, мэдээллийн аюулгүй байдлыг ханган, шуурхай хянан шийдвэрлэх,	Шийдвэрлэсэн хувь	Шийдвэрлэлтийн хувь 99.77%	Цахимаар ирсэн баримт бичгийг 94 хувиас доошгүй хувьд хүргэн шуурхай хянан, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	https://edoc.ub.gov.mn/ цахим хуудсаар 193 албан бичиг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэн, зөрчил дутагдалгүй ажилласан. Шийдвэрлэлтийн хувь 100.0%	2024.01.02-2024.12.31	100%
	Арга хэмжээ 3.5 Өргөдөл гомдолыг шуурхай хянан шийдвэрлэх,	Шийдвэрлэсэн дундаж хугацаа	Шийдвэрлэлтийн дундаж 4,5 хоног	Цахимаар ирсэн баримт бичгийг шуурхай хянан, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 1 өргөдөл, гомдол хүлээн авч, 06 дугаар сарын 07-ны өдөр бүрэн шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж 5 хоног 19 цаг 39 минут	2024.01.02-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
	Арга хэмжээ 3.6 Баримт бичгийг MNS5140:2011 стандартыг мөрдөн боловсруулах,	MNS5140:2011 стандартыг мөрдсөн эсэх	2023 онд 77 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн MNS5140:2011 стандартын дагуу төлөвлөсөн.	MNS5140:2011 стандартыг мөрдөн ажилласан байна.	33 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн MNS5140:2011 стандартын дагуу төлөвлөн боловсруулж, холбогдох газарт нь илгээсэн.	2024.01.02-2024.12.31	100%
	Арга хэмжээ 3.7 Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн, баримт бичиг хүлээн авах хуваарийн дагуу байгууллагын архивт шилжүүлэх,	Архивын нэгжийн тоо, тогтоосон хугацаанд хүргүүлсэн эсэх	2022 оны нийт 9 хавтас архивын нэгж үүсгэсэн.	Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн цэгцэлж, хуваарьт хугацаанд байгууллагын архивт өгсөн байна.	Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн, баримт бичиг хүлээн авах хуваарийн дагуу байгууллагын архивт 2023 оны 44 хадгаламжийн нэгж хүлээлгэн өгсөн. 2024 оны 4 хадгаламжийн нэгж үүсгэн ажиллаж байна.	2024.01.02-2024.12.31	100%
	Арга хэмжээ 3.8 Яам, нийслэл, дүүрэг, тамгын газар, хэлтсээс зохион байгуулсан олон нийтийн ажлуудад оролцох	Зохион байгуулсан ажилд оролцох хувь	Зохион байгуулсан ажлын 80-аас доошгүй хувьд оролцсон.	Зохион байгуулсан ажлын 80-аас доошгүй хувьд оролцсон байна.	2024.03.13- ЗДТГ-ын сарын аяны хүрээнд зохион байгуулагдсан Цасны баярын арга хэмжээнд оролцсон. 2024.03.21-Төрийн албаны зөвлөл- "Байгууллага, хувь хүний санхүүгийн удирдлага"- сэдэвт цахим сургалтанд хамрагдсан. 2024.03.23-ны өдрийн бүх нийтийн цэвэрлэгээнд оролцож буй дэргэдэх хэлтэс, албадын оролцоо,	2024.01.02-2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					цэвэрлэлтэнд хяналт тавьж ажилласан. 2024.03.28- Онцгой байдлын хэлтэс-Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх хүрээнд улс орон даяар зарлан мэдээлэх дуут дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуульд хамрагдсан. 2024.04.04- ЗДТГ-ын ёс зүйн дэд хороо-Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл танилцуулах арга хэмжээ 2024.04.06- Бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцсон. 2024.04.26 – ЗДТГ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран цахим хөгжлийг дэмжих хууль, тоон гарын үсгийн хэрэглээ, цахим ур чадварын талаар төрийн албан хаагчдад мэдлэг олгох сургалтанд хамрагдсан. 2024.05.03- Дүүргийн төсөвт байгууллагын нягтлан бодогч нарын дунд төрийн сангийн үйл ажиллагааны журмын шинэчлэлтийн талаарх мэдээлэл хүргэх сургалт, уулзалтыг зохион байгуулсан. Сонгуулийн тухай хууль болон Монгол хэл бичгийн судалгаа, сургалтад хамрагдсан.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					2024.05.06 – Төрийн албаны зөвлөл- "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа"-цахим сургалтанд хамрагдсан. 2024.05.16- Улсын дайчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэнгүүдэд зориулсан мэргэжил арга зүйн сургалтад хамрагдсан. 2024.05.25 - “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийн нэгдсэн арга хэмжээнд оролцсон. 2024.05.27- Нийслэлийн Цэргийн штабаас зохион байгуулсан Улсын дайчилгааны мэргэжилтэнүүдийг мэргэжил арга зүйгээр хангах тухай онлайн хэлэлцүүлэг, сургалт, 2024.09.26- Албан хэрэг, хөтлөлтийн сургалт, 2024.10.24-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт, 2024.11.07-Төрийн албан хаагчийн ёс зүй ба Эрүүл мэнд, 2024.11.08- Харилцааны сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүй сургалт, 2024.11.11-Хөгжлийн бодлого боловсруулах тухай, 2024.11.14-Төрийн албан хаагчийн ёс зүй (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх),		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан огноо	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
					2024.11.19-Төрийн албан хаагчийн ёс зүй (Дижитал ёс зүй)-н манлайллыг дэмжих, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх, сургалтад 2024.10.08- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд, 2024.10.25- "Агаарлая" спорт арга хэмжээнд тус тус хамрагдсан. 2024.11.25- Дүүргийн улс,орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, эд хариуцагч нарын дунд ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийг дэмжиж ажиллах хүрээнд "Боулинг" спорт тэмцээнийг хэлтсийн хамт олонтой хамтран амжилттай зохион байгууллаа.		

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.1.1.	Ерөнхий нягтлан бодогчийг түр орлон гүйцэтгэх	Хуулийн хугацаанд дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нэгтгэгдсэн эсэх, төрийн сангийн үйл ажиллагааны	Дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 82 байгууллагын	Хуулийн хугацаанд дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нэгтгэгдэн, төрийн	2023 оны санхүүгийн тайланд нэгтгэгдэх байгууллагуудын тайлангын өөрчлөлтийг тухай бүр Э-тайлан системд хүлээн авч, төсөв хоорондын тооцоог бүрэн хөтөлж нэгтгэсэн.	2024.01.02-2024.12.31	100%

		журам биелэгдсэн эсэх	2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-Тайланд нэгтгэгдэн, Нийслэл дэх Төрийн Аудитын газраар шалгуулж стандарт дүгнэгдэв.	сангийн үйл ажиллагааны журам биелэгдэн, "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн байна.	Хот нийтийн тохижилт үйлчилгээний Нийслэлийн төсвөөс санхүүжих зардлаас зам, талбайн цэвэрлэгээний 8 гүйцэтгэл, захиалагчийн хяналтын 1 гүйцэтгэл, ногоон байгууламжийн 8 гүйцэтгэл, нохой муур устгалын 1 гүйцэтгэл, гэрэлтүүлгийн ажлын 1 гүйцэтгэл тус хянан, орон нутгийн төсвийн зам талбайн цэвэрлэгээний (Засаг даргын захирамжаар) гүйцэтгэл зэрэг болон төрийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, хөтөлбөр, сангуудын нийт 127,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон ажиллалаа. Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Төрийн аудитын газарт 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг амжилттай нэгтгэн, "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 37 нэр төрлийн судалгаа, Нийслэлийн СТСХ-т 4 судалгаа, нийт 41 нэр төрлийн судалгааг нэгтгэн хүргүүлсэн.	
--	--	-----------------------	--	--	---	--

1.1.2	Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг үнэлэх	Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг үнэлэх эсэх		Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг үнэлсэн байна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах орон тооны бус зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолын 02 дугаар хавсралтаар батлагдсан худалдан борлуулах 40 нэр төрлийн 372 ширхэг эд зүйлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.	2024.01.02-2024.12.31	100%
1.1.3	Сонгуулийн тухай дагуу ажиллах	Сонгууль хуулийн хугацаанд явагдсан эсэх		Сонгууль хуулийн хугацаанд дууссан байна.	УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль зохион байгуулах ажилд 29 дүгээр тойргийн 16-1 дүгээр хэсгийн хорооны ахлагчаар томилогдон зөрчилгүй ажилласан.	2024.01.02-2024.12.31	100%
1.1.4	Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 37 дугаар хуралдаанаар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх	Санхүүгийн зөрчил дутагдал гаргасан эсэх, төрийн сангийн үйл ажиллагааны журам биелэгдсэн эсэх		Санхүүгийн зөрчил илрээгүй, төрийн сангийн үйл ажиллагааны журам биелэгдсэн байна.	Санхүүгийн дотоод хяналт хийх үйл ажиллагааг Эко хотын тээвэр ОНӨААТҮГ болон Хан-Уул Агро ОНӨААТҮГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааг хамруулан арилжааны банкууд дахь дансны хуулгыг түүвэрлэн, харилцахын журнал, өглөг, авлагын журналтай тулгах зэрэг ажиллагааг хийн, дүгнэлтийг танилцуулсан.	2024.11.04-2024.11.08	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн МНБ-ын тасралтгүй хөгжлийн сургалтад хамрагдах			Тасралтгүй боловсролын сургалтын хөтөлбөрт хамрагдсан байна.	Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн тасралтгүй боловсролын сургалтын хөтөлбөрийн хичээлийг 4 дүгээр сарын 05-ны өдрийн онлайн сургалтад хамрагдсан.	2024.04.01-2024.04.30	100%
2	Арга хэмжээ 2. Нийслэл, дүүргээс зохион байгуулсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтад хамрагдах			Төрийн албаны зөвлөл болон Нийслэл, дүүргээс зохион байгуулсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтад амжилттай суралцан, мэдлэг мэргэшил дээшилсэн.	2024.03.21-Төрийн албаны зөвлөл-“Байгууллага, хувь хүний санхүүгийн удирдлага”- сэдэвт цахим сургалтанд хамрагдсан. 2024.03.28- Онцгой байдлын хэлтэс-Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх хүрээнд улс орон даяар зарлан мэдээлэх дуут дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуульд хамрагдсан. 2024.04.04- ЗДТГ-ын ёс зүйн дэд хороо-Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл танилцуулах арга хэмжээ 2024.04.26 – ЗДТГ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран цахим хөгжлийг	2024.01.02-2024.12.31	100%

					дэмжих хууль, тоон гарын үсгийн хэрэглээ, цахим ур чадварын талаар төрийн албан хаагчдад мэдлэг олгох сургалтанд хамрагдсан. 2024.05.03- Дүүргийн төсөвт байгууллагын нягтлан бодогч нарын дунд төрийн сангийн үйл ажиллагааны журмын шинэчлэлтийн талаарх мэдээлэл хүргэх сургалт, Сонгуулийн тухай хууль болон Монгол хэл бичгийн судалгаа, сургалтад хамрагдсан. 2024.05.06 – Төрийн албаны зөвлөл- "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа"-цахим сургалтанд хамрагдсан. 2024.05.16, 2024.05.27- Нийслэлийн Цэргийн штабаас зохион байгуулсан Улсын дайчилгааны мэргэжилтэнүүдийг мэргэжил арга зүйгээр хангах тухай онлайн хэлэлцүүлэг, сургалт, 2024.09.26- Албан хэрэг хөтлөлтийн сургалт, 2024.10.24-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт, 2024.11.07-Төрийн албан хаагчийн ёс зүй ба Эрүүл мэнд, 2024.11.08- Харилцааны сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүй сургалт, 2024.11.11-Хөгжлийн бодлого боловсруулах тухай,		
--	--	--	--	--	--	--	--

					2024.11.14-Төрийн албан хаагчийн ёс зүй (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх), 2024.11.19-Төрийн албан хаагчийн ёс зүй (Дижитал ёс зүй)-н манлайллыг дэмжих, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх, сургалтад тус тус хамрагдсан.		
3	Арга хэмжээ 3. Удирдлагын Академийн "Төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн багц сургалт"-д хамрагдах			Мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийн хичээлийг дүүргэж, төгссөн байна.	Удирдлагын Академийн төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтанд 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрүүдэд амжилттай хамрагдан сертификат авсан.	2024.01.02- 2024.06.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төсвийн мэргэжилтэн

 Ц.Лхагвасүрэн

2024.11.28

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН Ц.ЛХАГВАСҮРЭНГИЙН
НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН ХУУДАС


Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Ерөнхий нягтлан бодогчийг түр орлон гүйцэтгэх	Дүүргийн Засаг дарга	Хуулийн хугацаанд дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайлан нэгтгэгдсэн эсэх, төрийн сангийн үйл ажиллагааны журам биелэгдсэн эсэх	Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 82 байгууллагын 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн яамны нэгтгэлийн Э-тайланд нэгтгэгдэн, Нийслэл дэх Төрийн Аудитын газраар шалгуулж "Өөрчлөлтгүй" дүгнэгдэв.	Хуулийн хугацаанд дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төрийн үйл ажиллагааны журам биелэгдэн, "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн байна.	2024.01.02	2024.06.30
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Албадлагын арга хэмжээ авсантай хурал авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг үнэлэх	Дүүргийн Засаг дарга	Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хурал авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг үнэлэх		Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хурал авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг зах зээлийн үнэд тулгуурлан үнэлсэн байна.	2024.01.02	2024.10.15

3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Сонгуулийн тухай хуулийн дагуу ажиллах	Дүүргийн Засаг дарга	Сонгууль хуулийн хугацаанд явагдсан эсэх		Сонгууль хуулийн хугацаанд байна. дууссан	2024.01.02	2024.10.15
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 37 дугаар хуралдаанаар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх	Дүүргийн Засаг дарга	Санхүүгийн зөрчил дутагдал гаргасан эсэх, төрийн сангийн үйл ажиллагааны журам биелэгдсэн эсэх		Санхүүгийн илрээгүй, зөрчил төрийн сангийн үйл ажиллагааны журам биелэгдсэн байна.	2024.11.04	2024.11.08

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:


Төсвийн мэргэжилтэн
(Албан тушаал)


..... (Ц.Лхагвасүрэн)
(Нэр, гарын үсэг)

2024. 01. 05
.....
(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
(Албан тушаал)


..... (М.Цогзолмаа)
(Нэр, гарын үсэг)

2024. 01. 05
.....
(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН Ц.ЛХАГВАСҮРЭНГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. " Санхүү, төсвийн чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дүүргийн орон нутгийн төсвийн төслийг боловсруулж батлуулах, тайлагнах."					
1.	Арга хэмжээ 1.1.	60	7	67	
2.	Арга хэмжээ 1.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 1.3.	60	10	70	
Зорилт 2. " Төсөвт байгууллагуудын төсвийн саналыг хуулийн хугацаанд хүлээн авч, норм, нормативыг үндэслэн үр ашигтай төсөвлөх, төсвийн зарцуулалтад хяналт тавих."					
1.	Арга хэмжээ 2.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 2.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 2.3.	60	10	70	
Зорилт 3. "Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх."					
1.	Арга хэмжээ 3.1.	60	10	70	
2.	Арга хэмжээ 3.2.	60	10	70	
3.	Арга хэмжээ 3.3.	60	10	70	
4.	Арга хэмжээ 3.4.	60	10	70	
5.	Арга хэмжээ 3.5.	60	10	70	
6.	Арга хэмжээ 3.6.	60	10	70	
7.	Арга хэмжээ 3.7.	60	10	70	
8.	Арга хэмжээ 3.8.	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар 1.	60	10	70	
2.	Үүрэг даалгавар 2.	60	10	70	
3.	Үүрэг даалгавар 3.	60	10	70	
4.	Үүрэг даалгавар 4.	60	10	70	
Дундаж оноо:				69,75	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1.		15,0	
2.	Арга хэмжээ 2.		15,0	
3.	Арга хэмжээ 3.		15,0	
Дундаж оноо			15,0	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7,0	
2.	Дүн шинжилгээ хийх	7,0	
3.	Асуудал шийдвэрлэх	7,0	
4.	Хариуцлагатай байдал	5,0	
5.	Ажлын цаг ашиглалт	7,0	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		6,6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8,0
2.	Багаар ажиллах	8,0
3.	Харилцаа	8,0
Дундаж оноо		8,0

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	69,75
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15,0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6,6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8,0
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар		99,35

хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар
хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтэс


2024.12.13 (огноо)

/М.Цогзолмаа/

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Төсвийн мэргэжилтэн



/Ц.Лхагвасүрэн/

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

2024.12.13 (огноо)

Л.Отгонбаяр

/...../
(албан хаагчийн нэр)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг
хариуцсан мэргэжилтэн

(албан тушаал)

(гарын үсэг)

2024.12.13 (огноо)

Б.Саранцацрал

/...../
(албан хаагчийн нэр)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Засаг даргын Тамгын газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

2024.12.13 (огноо)



3.Буянт